














№	Айчигийн зорилт	БОНХЯ ажлын хэсгийн санал	Үндэсний хөтөлбөр, бодлогын баримт бичигт тулгуурласан зорилт (санал)	Эх сурвалж
Стратегийн зорилго А:	Засгийн газрын болон нийгмийн зонхилох чиг хандлагыг биологийн олон янз байдлын хомсдлын шалтгаанд хандуулах			
	Зорилт 1 2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр хүмүүс биологийн олон янз байдлын үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгож, түүнийг хамгаалах, зохистой ашиглах алхамуудыг хийж эхлэх	2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр хүмүүс биологийн олон янз байдлын тухай ойлголттой болох, ач холбогдлыг ойлгож, түүнийг хамгаалах алхамуудыг хийж эхлэх, цэцэрлэг, сургуулиудын хичээлийн програмд албан ёсоор оруулж батлуулах, хэрэгжүүлж эхлэх;	2021 он гэхэд бүх түвшний боловсролын агуулгад тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусгах, үндэсний түүх, соёлыг бахархан дээдэлж, бусдын соёлд хүндэтгэлтэй хандах үзэл, бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадвар төлөвшүүлсэн байна.	А.Боловсрол үндэсний хөтөлбөр 2010-2021 он Стратегийн зорилт 2.2-г Б.Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр 2011-2020 5 дугаар зорилтын 3.3.5.5-д В. Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр (төсөл) 5 дугаар зорилтын 3.3.5.4 Г. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, (2011-2021) стратеги зорилт 5, үйл ажиллагаа 3.5.1-3.5.10 Д. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, тэргүүлэх чиглэл 9.4, зорилт 1 <i>Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсрол Үндэсний хөтөлбөр 2009-2019</i>


	<p>Зорилт 2 2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр биологийн төрөл зүйлийн үнэ цэнийн тухай асуудал үндэсний болон орон нутгийн хөгжил, ядуурлыг бууруулах стратегийн бодлого төлөвлөлт, үндэсний төсөв болон тайлангийн системүүдэд тусгагдсан байх</p>	<p>2015 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр биологийн төрөл зүйлийн талаар үндэсний болон аймаг, нийслэл, орон нутгийн хөгжил, ядуурлыг бууруулах стратегийн бодлого, төлөвлөлт, үндэсний болон тайлангийн системүүдэд тусгагддаг болсон байх;</p>	<p>2015 он гэхэд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ногоон хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдсан Монгол улсын газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчилсэн баталсан байна.</p>	<p>Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийн төсөл, Хэрэгжих хугацаа 2020 он хүртэл</p> <p>“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолын хавсралт</p> <p>Гурав.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын чиглэл</p> <p>Монгол мал хөтөлбөр</p>
	<p>Зорилт 3 2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг багасгах үүднээс хор хохирол учруулахуйц үйл ажиллагааг дэмжихгүй байх, харин түүнийг хамгаалах, зүй зохистой ашиглахыг дэмжсэн Конвенцийн болон олон улсын хууль тогтоомжтой нийцэхүйц арга хэмжээг үндэсний нийгэм эдийн засгийн бодлогодоо тусгах</p>	<p>2015 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах үүднээс хор хохирол учруулахуйц үйл ажиллагааг дэмжиж, батлахгүй байх, харин түүнийг хамгаалах, шинжлэх ухааны үндэслэлтэй зохистой ашиглахыг дэмжсэн Конвенцийн болон олон улсын хууль тогтоомжтой нийцэхүйц арга хэмжээг үндэсний нийгэм эдийн засгийн бодлогодоо тусгаж, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;</p>	<p>2020 он гэхэд эдийн засгийн салбаруудад байгаль орчны стратегийн үнэлгээ хийгдсэн байна (Ялангуяа ХАА, Эрдэс баялаг, Боловсруулах салбар гэх мэт).</p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012 он</p>
	<p>Зорилт 4 2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр Засгийн газар болон бизнес санхүүгийн бүх талууд зохистой үйлдвэрлэл,</p>	<p>2015 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр Засгийн газар болон бизнес санхүүгийн бүх талууд биологийн төрөл зүйлүүдэд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээг дэмжсэн</p>	<p>2017 он гэхэд Ногоон хөгжлийн үзэл баримтлал батлагдан салбаруудын бодлогод бүрэн тусгагдсан байна.</p>	<p>Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийн төсөл, Хэрэгжих хугацаа 2020 он хүртэл</p>




	хэрэглээг дэмжсэн төлөвлөлтүүдийг хэрэгжүүлж эхлэх, экологийн тодорхой хязгаарын хэмжээнд байгаль орчны нөөцийг ашигладаг болсон байх	төлөвлөлтүүдийг хэрэгжүүлж эхлэх, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүй бөгөөд түүнийг нөхөн сэргээх боломжтой хэмжээнд байгаль орчны нөөцийг ашигладаг болсон байх;		
Стратегийн зорилго Б:	Биологийн олон янз байдалд үзүүлэх шууд дарамтыг бууруулах, тогтвортой хэрэглээг хөхиүлэн дэмжих			
	Зорилт 5 2020 он гэхэд байгалийн нөөцийн ялангуяа ойн нөөцийн хомсдлыг хамгийн багадаа тал хувиар бууруулах боломжит нөхцөлд тэглэх болон түүний элэгдэл доройтлыг их хэмжээгээр багасгах	2020 он гэхэд байгалийн нөөцийн, ялангуяа ой, усны сангийн нөөцийн хомсдлыг хамгийн багадаа тал хувиар бууруулах, болон элэгдэл доройтлыг их хэмжээгээр багасгах;	2030 он гэхэд Монгол орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 9 хувьд хүргэж, менежментийг сайжруулсан байна.	Төрөөс ойн талаар баримтлах бодлого 2014 – 2030 (төсөл) Монгол улсын үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал 2010 он Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд 2005 – 2021
	Зорилт 6 2020 он гэхэд загас усны амьтан болон ургамлын зөв зохицуулалттай менежмент хийх зүй зохистой ашиглах үүний тулд экосистемд суурилсан хууль эрх зүйн актуудыг хэрэглэж, хууль бус загас агналтыг багасгах, цөөрч буй төрөл зүйлүүдэд хяналт тавих, загас агнуурыг төрөл зүйлийн тоо болон экосистемийн төлөв байдал,	2020 он гэхэд загасны зөв зохицуулалттай менежмент хийх, зүй зохистой ашиглах, хууль бус загас агналтыг бууруулах, орон нутгийн иргэдийн хамгаалалттай зохистой ашиглалтыг дэмжиж цөөрч буй төрөл зүйлүүдэд хяналт тавиулах, загас агнуурыг экосистемд нөлөөлөхгүйгээр экосистемд нөлөөлөхгүйгээр авч хэрэгжүүлэх;	2020 он гэхэд Доод цагаан, Буйр, Өгий, Ачит, Голбо, Улаагчны Хар, Баян, Үүрэг, Хяргас, Айраг, Хотон, Хоргон, Даян, Хонгор, Хөх, Хар-Ус, Хар, Дөргөн , Бөөнцагаан зэрэг нууруудыг хамгааллын статус, загасны нөөцөд нь тулгуурлан менежмент нэвтрүүлсэн байна.	Агнуурын загас хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр (2008-2015)




	зах зээлд нөлөөлөхгүйгээр экологийн тодорхой хязгаарын дотор авч үзэх			
	Зорилт 7 2020 он гэхэд ХАА, ой болон усан сан бүхий газруудын тогтвортой менежмент бий болсоноор биологийн олон янз байдал хамгаалагдсан байх.	2020 он гэхэд ХАА, Ой болон усны эх бүхий газруудын тогтвортой менежментийг бий болгосноор тухайн орны биологийн олон янз байдал хамгаалагдсан байх;	2020 он гэхэд хөдөө аж ахуйн салбарт газартай харилцах соёл, зохион байгуулалтыг шинэчилж, бүс нутгийн байгаль, цаг уурын хувьсал өөрчлөлтөд зохицсон тогтвортой менежментийг бий болгон биологийн олон янз байдлыг хамгаалсан байна. <i>ХАА-н тогтвортой хөгжлийг дэмжиж, ногоон технологид суурилсан боловсруулах үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлж, нийт аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийг 2020 онд 40 хувьд хүргэсэн байна.</i>	Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1997-2000; 2001-2010; 2010-2020) Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийн төсөл, Хэрэгжих хугацаа 2021 он хүртэл
	Зорилт 8 2020 он гэхэд шим тэжээлийн илүүдлээс гарсан бүх төрлийн бохирдлыг экосистем болон биологийн олон янз байдалд хор хөнөөлгүй байх түвшинд хүргэх	2020 он гэхэд шим хүнс тэжээлийн илүүдлээс гарсан бүх төрлийн бохирдлыг экосистем болон биологийн олон янз байдалд хор хөнөөлгүй түвшинд хүргэх;	2021 он гэхэд усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалттай бүсийн дэглэмийг мөрдүүлж хэвшүүлсэн байна.	“Ус” үндэсний хөтөлбөр /2010-2015, 2016-2021 он/
	Зорилт 9 2020 он гэхэд харь зүйл, тэдгээрийн суурьшлыг судлах, хяналтад авч ангилах, нэн тэргүүнд анхааран авч үзэх зарим зүйлийн талаар хэмжилт судалгаа хийж тэдгээрийг	2015 он гэхэд харь зүйлүүдийн тархац, биологи, экологийн нөхцлийн бүрэн судлах, мониторинг, хяналтад авч, ангилах, анхаарал татсан хөнөөлтэй зүйлүүдийн талаар нарийвчилсан судалгаа хийх, өөр газар нутагт дахин суурьшихаас	2020 он гэхэд Монгол орны харь зүйл амьтны судалгаа хийх, түрэмгийлэгч харь зүйл тэдгээрийн экосистемд үзүүлж буй нөлөөллийг судлах, харь зүйлийн хяналтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна	Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр “Амьтны тухай” хууль (2012) “Харь амьтныг ашиглах” журам (2013)

	тухайн газар нутагт суурьшихаас сэргийлэх арга хэмжээг авах.	сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж эхлэх, тайланг холбогдох газруудад хүргүүлдэг болсон байх		
	Зорилт 10 2015 он гэхэд уур амьсгалын өөрчлөлт болон далайн хүчиллэгжих үйл явцын нөлөөгөөр шүрэн арлын хад болон бусад эмзэг экосистемүүдэд үзүүлж буй гадны нөлөөллийг бууруулж, экосистемийн харилцан үйлчлэл, уялдаа холбоог бэхжүүлэх	2015 он гэхэд уур амьсгалын өөрчлөлт эмзэг экосистемүүдийг судлан тогтоож, харилцан үйлчлэл, уялдаа холбоог хадгалах талаар бодлого боловсруулах бэхжүүлэх	2015 он гэхэд уур амьсгалын өөрчлөлт эмзэг экосистемүүдийг судлан тогтоож, харилцан үйлчлэл, уялдаа холбоог хадгалах талаар бодлого боловсруулах бэхжүүлсэн байна. 2015 он гэхэд “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 20%-иос доошгүй хувийг гүйцэтгэх ба бүс нутгийн онцлогт тохируулан цөлжилттэй тэмцэх нийтлэг арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх, цөлжилтийн сөрөг нөлөөллийг багасгах, түүнд дасан зохицох арга замыг тодорхойлсон байна.	“Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2003 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2005 оны 44 дүгээр тогтоол
Стратегийн зорилго В:	Экосистем, зүйл, генетикийн олон янз байдлыг хамгаалснаар биологийн олон янз байдлын төлөвийг сайжруулах;			
	Зорилт 11 2020 он гэхэд биологийн олон янз байдал болон экосистемийн хувьд онцгой ач холбогдол бүхий экосистемийг илэрхийлж чадах бүс нутгийг нэгтгэх	2015 он гэхэд биологийн олон янз байдал болон экосистемийн хувьд онцгой ач холбогдол бүхий бүс нутгийн 30 хувь, мөн усны эх орчмын 50 хувийг хамгаалж, байгалийн экосистемийн үзэсгэлэнт бүс нутгуудыг бий	2030 он гэхэд экосистемийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд 2005 – 2021 “Ус” үндэсний хөтөлбөр /2010-2015, 2016-2021 он/

	<p>замаар хуурай газрын доод тал нь 17 хувь, далайн эрэг орчмын 10-хувийг хамгаалж, хуурай газар болон тэнгисийн үзэмжит бүс нутгуудыг бий болгох.</p>	<p>болгох</p>	<p>нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэж, менежментийг сайжруулсан байна.</p> <p>2021 он гэхэд гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 80 хувьд хамаарах газрын хилийг нарийвчлан тогтоож улсын болон орон нутгийн хамгаалалтад авна. Энэ хэсэгт явагдаж байгаа болон явуулахаар төлөвлөж байгаа сөрөг нөлөө бүхий аливаа үйл ажиллагааг багасгаж, зогсоох арга хэмжээг авсан байна.</p>	
	<p>Зорилт 12 2020 он гэхэд устах аюулд орсон төрөл зүйлүүд хамгаалагдаж чадсан байх, тэдгээрийн хамгаалалтын байдал сайжирсан, тогтворжсон байх.</p>	<p>2025 он гэхэд устах аюулд орсон төрөл зүйлүүдийг бүрэн хамгаалж чадах хууль эрх зүй, нийгэм эдийн засгийн нөхцлийг бүрдүүлсэн байх, тоо толгой, тархац нутаг тогтвортой болсон байх</p>	<p>2021 он гэхэд нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн болсон байна.</p>	<p>Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр 2011-2020</p>
	<p>Зорилт 13 2020 он гэхэд генетикийн төрөл зүйл болох тарималжуулсан ургамал, фермийн болон гэрийн тэжээмэл амьтад, тэдгээрийн зэрлэг овог төрөл зүйл болон нийгэм-эдийн засаг болон ёс заншлын ач холбогдол бүхий амьтдыг хамгаалах, тэдгээрийн генетикийн доройтолд хамгаалсан арга хэмжээг боловсруулах.</p>	<p>2018 он гэхэд генетикийн төрөл зүйл болох тарималжуулсан ургамал, фермийн болон гэрийн тэжээмэл амьтад, тэдгээрийн зэрлэг овог, төрөл зүйл болон нийгэм-эдийн засаг, соёл, ёс заншлын ач холбогдол бүхий амьтдыг хамгаалах, тэдгээрийн генийн доройтлоос сэргийлэх арга хэмжээг боловсруулж батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байх;</p>	<p>2021 он гэхэд Монгол малын удмын сан, таримал ургамал, нутагшсан сорт тэдгээрийн зэрлэг овог, төрөл, зүйлийг бүртгэлжүүлж, нөөцийн сан бүрдүүлэх, хамгаалах, зориудаар өсгөн үржүүлэх замаар генийн ядуурлыг хязгаарласан байна.</p>	<p>Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-2010, БОЯБ-ыг хадгалах, нөөцийн хомсдолоос сэргийлэх</p> <p>Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, 2008 Бу 2007-2015: Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, 2001</p>

				<p>Таримал ургамлын үр, сортын тухай, 1999</p> <p>Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр 2011-2020</p> <p>Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөрт: ВҮ 2021</p>
Стратегийн зорилго Г:	Биологийн олон янз байдал болон бүх төрлийн экосистемийн үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх			
	Зорилт 14 2020 он гэхэд байгаль орчны чухал үйлчилгээ үзүүлдэг ялангуяа эмэгтэйчүүд нутгийн уугуул оршин суугчид ядуу эмзэг бүлгүүдэд ихээхэн ач холбогдол бүхий тухайлбал ус зэрэг хүний эрүүл мэнд амьжиргаанд чухал нөлөөтэй экосистемийг хамгаалах нөхөн сэргээх.	2020 он гэхэд малчид, уугуул оршин суугчид, ядуу, эмзэг бүлгүүдэд ач холбогдолтой ундны ус, эрүүл мэнд, амьжиргаанд чухал үйлчилгээг үзүүлдэг экосистемүүдийн аюулгүй байдлыг хангаж хамгаалах, нөхөн сэргээсэн байна;	2018 он гэхэд экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, ач холбогдлыг тооцсоны үндсэн дээр түүний нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тогтвортой хадгалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах механизмыг бүрдүүлсэн байна.	Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийн төсөл, Хэрэгжих хугацаа 2021 он хүртэл

	<p>Зорилт 15 2020 он гэхэд доройтолд орсон экосистемийн 15-аас доошгүй хувийг хамгаалж нөхөн сэргээснээр экосистемийн уян хатан байдал сайжирч биологийн олон янз байдлаас үүдэлтэй нүүрстөрөгчийн хэмжээ ихсэж энэ нь улмаар уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах дасан зохицох цөлжилттэй тэмцэхэд тус нэмэр болох.</p>	<p>2020 он гэхэд доройтолд орсон болон уул уурхайн нөлөөлөлд орсон экосистемийн 50-аас доошгүй хувийг хамгаалж, нөхөн сэргээснээр экосистемийн уян хатан байдал сайжруулснаар уур амьсгалын өөрчлөлтөнд эерэг нөлөөг үзүүлэх, цөлжилттэй тэмцэхэд тус нэмэр оруулж эхэлсэн байх;</p>	<p>2021 он гэхэд малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулах, бэлчээрийн даац хэтэрсэн нутагт байлгах малын тооны дээд хязгаарыг тогтоож, түүнээс давуулахгүй байлгах эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгосон байна.</p> <p><i>Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, газрын хэвлийг ашиглагч нь хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг үр дүнтэй болгоно.</i></p>	<p>Монгол мал хөтөлбөр (201-2021)</p> <p>Монгол улсын үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал 2010 он</p>
	<p>Зорилт 16 2015-он гэхэд Генетикийн нөөцийг хүртэх түүнээс гарах үр ашгийн шударга тэгш хуваарилах тухай Нагояагийн Протокол үндэсний хууль тогтоомжид нийцэн хүчин төгөлдөр болж хэрэгжсэн байх.</p>	<p>2015 он гэхэд генетик нөөцийг үр ашгийг хүртэх, үр ашгийн шударга тэгш хуваарилах тухай Нагояагийн Протокол үндэсний хууль тогтоомжид нийцэн хүчин төгөлдөр болж хэрэгжсэн байх;</p>	<p>2016 он гэхэд генетикийн нөөцийг ашиглах, түүний үр өгөөжийг хүртэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.</p> <p><i>2021 он гэхэд өргөн хэрэглэгддэг, эдийн засгийн ач холбогдолтой генийн нөөцийг бүртгэлжүүлж түүнээс ашиг хүртэж эхэлсэн байна.</i></p>	<p>Шинэчлэлийн Засгийн газрын хөтөлбөр 2012-2016 он</p>
<p>Стратегийн зорилго Д:</p>	<p>Оролцогч талуудын чадавхийг бэхжүүлснээр хэрэгжилтийг хангах;</p>			
	<p>Зорилт 17 2015 он гэхэд Конвенцийн талууд Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгайсан шинэчилсэн бодлогын баримт бичигтэй болсон байх.</p>	<p>2014 он гэхэд Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болж, түүнийг тусгасан шинэчилсэн бодлогын баримт бичигтэй болсон байх;</p>	<p>2015 он гэхэд Биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглалтыг үндэсний болоод салбарын бодлогуудын түвшинд уялдуулан зохицуулах биологийн олон янз байдлын үндэсний стратеги төлөвлөгөөтэй болсон байна.</p>	

	<p>Зорилт 18 2020 он гэхэд нутгийн уугуул иргэд оршин суугчдын байгаль орчинд хандах хандлага түүний нөөц баялгийг зүй зохистой ашиглаж ирсэн уламжлалт зан заншлыг хууль ёсоор бүх шатанд хүлээн зөвшөөрч дэмжин, тэдгээрийн оролцоог үндэсний олон улсын хууль дүрэм болон Конвенцийн хэрэгжилтэнд бүрэн тусгасан байх.</p>	<p>2015 он гэхэд нутгийн иргэд, оршин суугчдын байгаль орчинд хандах хандлага, түүний нөөц баялгийг зүй зохистой ашиглаж ирсэн уламжлалт зан заншлыг хууль ёсоор бүх шатанд хүлээн зөвшөөрч дэмжүүлэх, тэдгээрийн оролцоог орон нутаг, үндэсний, олон улсын хууль, дүрэм болон Конвенцийн хэрэгжилтэд бүрэн тусгуулсан байх;</p>	<p>2020 он гэхэд байгальдаа зохицсон уламжлалт арга ажиллагаа, орчин үеийн техник, технологийн тэргүүний ололтыг бүтээлчээр хослон ашиглах замаар экологийн тэнцлийг хангах үйл ажиллагааг байгаль орчин, эдийн засаг, нийгмийн нэгдсэн бодлого, зохицуулалтын арга, механизмаар хэрэгжүүлж хэвшсэн байна.</p> <p><i>Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 8-р бүлгийн (Байгалийн нөөцийн хамтын менежмент) 45-р зүйлийн хэрэгжилттэй холбоотой зорилт тусч болох</i></p>	<p>Төрөөс экологийн талаар баримтлах бодлого 1997 он</p> <p>Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр 2020 он (төсөл)</p> <p>"Монгол мал" Үндэсний хөтөлбөр</p> <p>"Ус" Үндэсний хөтөлбөр /2010-2015, 2016-2021 он/</p> <p>Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал</p>
	<p>Зорилт 19 2020 оны түвшинд Биологийн олон янз байдлын өөрчлөлт, хандлагыг тогтоосон шинжлэх ухааны суурь судалгаа арга технологийг сайжруулж, үр дүнг өргөн хүрээгээр мэдээлж сурталчилж ашигладаг болох.</p>	<p>2015 оны түвшинд Биологийн олон янз байдлын өөрчлөлт, хандлагыг тогтоосон шинжлэх ухааны суурь судалгаа, арга технологийг олон улсын түвшинд хүрэхүйц сайжруулж гарах үр дүнг үндэсний хэнмжээнд өргөн хүрээгээр сурталчлан таниулж, шаардлагатай хэрэглээний түвшинд заавал ашигладаг болсон байх;</p>	<p>2016 он гэхэд Байгаль орчны улсын мэдээллийн төв сангийн мэдээний нэр төрөл хүртэцийг сайжруулан шийдвэр гаргахад нөлөөлөх /ашиглах механизмыг бүрдүүлсэн байна.</p>	<p>Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого</p> <p>Байгаль орчны сайд, Сангийн сайдын 1999 оны 154/201 тоот тушаалын хавсралт</p>
	<p>Зорилт 20 2020-оны түвшинд Биологийн олон янз байдлын стратегийн төлөвлөгөө 2010-2020 үр ашигтай хэрэгжүүлэхэд зориулагдах санхүүжилтийг боломжит эх үүсвэрээс бүрдүүлэх нөөц</p>	<p>2020 оны түвшинд Биологийн олон янз байдлын стратегийн төлөвлөгөө 2013-2020 үр ашигтай хэрэгжүүлэхэд зориулагдах санхүүжилтийг боломжит эх үүсвэрээс бүрдүүлэх, нөөц ашиглалтын стратегийг амжилттай хэрэгжүүлснээр</p>		

	ашиглалтын стратегийг амжиттай хэрэгжүүлснээр одоогийн түвинг сайжруулах мөн туайн зорилтыг хэрэгжүүлэхэд талууд нөөцийн хэмжээг үнэлж тайлагнасны үндсэн дээр хувь хэмжээг тохирох.	одоогийн түвшинг сайжруулах, мөн тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд талууд нөөцийн хэмжээг үнэлж, тайлагнасны үндсэн дээр хувь хэмжээг тохирох зэрэг болно.		
--	--	--	--	--